



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/21/СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын дөрөвдүгээр газрын захирал,
тэргүүлэх аудитор: Я.Самбууням

Утас: 260949

Цахим хаяг: sambuunyamyia@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Хосжаргал

Утас: 261628

Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Энхжин

Утас: 260512

Цахим хаяг: Enkhjinb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	15
3.5.1 Мөнгөн хөрөнгө	15
3.5.2 Авлага	16
3.5.3 Урьдчилгаа.....	17
3.5.4 Бараа материал	17
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	18
3.5.6 Өр төлбөр.....	18
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	19
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	21
3.8 Аудитын гол асуудал.....	21
3.9 Шилэн дансны мэдээлэл	22
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	22
4. Аудитын илрүүлэлт.....	23
Албан шаардлага	23
Зөвлөмж.....	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	25
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	31

Товчилсон үгийн жагсаалт

АЕГ	Архивын ерөнхий газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БХЗХНБАА	Банк хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын алба
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ГХХНТОС	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан
ГХУСАЗБАА	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын алба
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
МШУТ	Мэдээллийн шуурхай удирдлагын төв
НУБГ	Нийслэлийн улсын бүртгэлийн газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОӨГ	Оюуны өмчийн газар
ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УБГ	Улсын бүртгэлийн газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХОБА	Хөрөнгө оруулалт, барилгын алба
ХОБЗА	Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн алба
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХЗТТ	Хууль зүйн туслалцааны төв
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШГА	Шийдвэр гүйцэтгэх алба
ШТН	Шохой, тоосго, нүүрс
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1331

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/	
	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	233,842,197.5	303,089,887.7
МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,296,356.7	34,730,027.5
АВЛАГА	86,652,963.5	90,474,625.8
УРЬДЧИЛГАА	5,715,112.2	6,326,577.7
БАРАА МАТЕРИАЛ	106,261,841.8	159,658,640.4
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	915,923.3	11,900,016.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	775,959,236.2	938,327,659.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	775,959,236.2	938,327,659.8
Биет хөрөнгө	619,998,555.4	649,510,104.7
Биет бус хөрөнгө	153,397,660.2	286,170,336.6
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	2,563,020.6	2,647,218.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,009,801,433.7	1,241,417,547.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР	123,399,233.5	123,483,459.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	123,399,233.5	123,483,459.6
Богино хугацаат зээлийн өглөг	810,000.0	800,000.0
Өглөг	58,277,357.0	48,772,637.2
Урьдчилж орсон орлого	64,311,876.5	73,910,822.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	886,402,200.2	1,117,934,088.0
Засгийн газрын хувь оролцоо	886,402,200.2	1,117,934,088.0
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	350,424,343.8	482,674,841.0
Хуримтлагдсан үр дүн	322,416,122.1	425,328,696.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	213,561,734.3	209,930,550.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,009,801,433.7	1,241,417,547.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/	
	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	615,929,560.3	725,508,721.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,434,506.6	91,034,233.9
Нийтлэг татварын бус орлого	77,179,776.4	90,114,460.6
Тусламжийн орлого	254,730.2	919,773.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	538,495,053.8	634,474,487.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	545,713,408.2	620,815,875.9
УРСГАЛ ЗАРДАЛ	545,519,792.0	620,815,875.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493,118,101.5	567,593,879.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,374,899.4	347,561,134.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,203,453.1	15,148,576.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,347,098.8	17,816,040.0
Хангамж, бараа материалын зардал	26,694,113.7	27,269,257.1
Нормативт зардал	37,842,515.7	47,478,059.2
Эд хогшил, урсгал засварын зардал	6,814,329.3	9,541,417.0
Томилолт, зочны зардал	2,050,438.5	1,023,259.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,634,036.8	26,465,217.5
Бараа үйлчилгээний бусад зардал	59,157,216.2	75,290,918.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,401,690.5	53,221,996.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	193,616.1	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	70,216,152.2	104,692,845.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	63,971.8	14,143.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,023,470.9	4,796,994.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	66,256,653.1	99,909,793.4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/ мянган төгрөгөөр/			
Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	805,410,459.2	-	805,410,459.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,976,577.6	-	6,976,577.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	812,387,036.8	-	812,387,036.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,122,387.5	-	3,122,387.5
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,637,276.1	-	4,637,276.1
Зарласан ногдол ашиг	(1,153.3)	-	(1,153.3)
Тайлант үеийн үр дүн	66,256,653.1	-	66,256,653.1
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	886,402,200.2	-	886,402,200.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,011,290.9	-	3,011,290.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	889,413,491.1	-	889,413,491.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(3,631,183.8)	-	(3,631,183.8)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	132,250,497.2	-	132,250,497.2
Зарласан ногдол ашиг	(8,510.0)	-	(8,510.0)
Тайлант үеийн үр дүн	99,909,793.4	-	99,909,793.4
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,117,934,088.0	-	1,117,934,088.0

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/	
	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	776,617,380.5	863,322,391.7
ТАТВАРЫН ОРЛОГО	22,929,664.7	16,297,544.9
Бусад татвар, төлбөр, хураамж	22,929,664.7	16,297,544.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,929,664.7	16,297,544.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	212,820,144.1	205,190,353.3
Нийтлэг татварын бус орлого	212,820,144.1	205,029,735.3
Тусламжийн орлого	-	160,618.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	540,867,571.8	641,834,493.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	706,979,512.7	794,468,707.7
УРСГАЛ ЗАРДАЛ	706,979,512.7	794,468,707.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,470,592.2	701,916,673.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,902,310.6	349,499,885.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,654,354.2	15,803,708.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,869,509.1	17,992,703.6
Хангамж, бараа материалын зардал	33,233,226.3	40,641,979.0
Нормативт зардал	37,968,010.2	51,436,953.8
Эд хогшил, урсгал засварын зардал	10,476,625.6	18,705,376.9
Томилолт, зочны зардал	2,079,414.9	1,124,090.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,944,479.4	46,661,623.9
Бараа үйлчилгээний бусад зардал	153,342,661.9	160,050,352.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,508,920.5	92,552,034.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	69,637,867.8	68,853,684.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	54,178,597.7	68,415,234.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,178,597.7	68,415,234.4
Дотоод эх үүсвэрээр	54,178,597.7	68,415,234.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(54,178,597.7)	(68,415,234.4)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	414,177.8	(4,778.8)
Бусад эх үүсвэр	1,173,945.9	6,121,083.8
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	759,768.0	6,125,862.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	15,873,448.0	433,670.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,422,908.7	34,296,356.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,296,356.7	34,730,027.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	605,191,728,500.00	621,116,038,591.55	(15,924,310,091.55)	102.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,142,273,100.00	570,990,999,384.05	4,151,273,715.95	99.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,501,012,700.00	521,416,764,501.26	4,084,248,198.74	99.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	343,345,571,600.00	341,657,376,215.37	1,688,195,384.63	99.51
210101	Үндсэн цалин	204,844,427,800.00	204,211,773,134.54	632,654,665.46	99.69
210102	Нэмэгдэл	122,501,381,100.00	121,592,168,411.03	909,212,688.97	99.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,275,221,700.00	4,200,509,795.46	74,711,904.54	98.25
210104	Урамшуулал	2,346,211,700.00	2,303,820,838.61	42,390,861.39	98.19
210105	Гэрээт ажлын хөлс	9,378,329,300.00	9,349,104,035.73	29,225,264.27	99.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,590,118,400.00	15,008,639,227.26	581,479,172.74	96.27
210201	Тэтгэврийн даатгал	6,911,507,600.00	6,561,709,284.06	349,798,315.94	94.94
210202	Тэтгэмжийн даатгал	676,129,700.00	665,810,546.34	10,319,153.66	98.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	309,737,800.00	296,748,137.28	12,989,662.72	95.81
210204	Ажилгүйдлийн даатгал	197,165,000.00	192,844,142.58	4,320,857.42	97.81
210205	Эрүүл мэндийн даатгал	7,495,578,300.00	7,291,527,117.00	204,051,183.00	97.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,871,776,600.00	17,734,884,604.57	136,891,995.43	99.23
210301	Гэрэл, цахилгаан	7,104,734,000.00	7,006,610,677.76	98,123,322.24	98.62
210302	Түлш, халаалт	7,703,721,900.00	7,715,605,847.13	(11,883,947.13)	100.15
210303	Цэвэр, бохир ус	1,482,795,700.00	1,438,006,288.47	44,789,411.53	96.98
210304	Байрны түрээс	1,580,525,000.00	1,574,661,791.21	5,863,208.79	99.63
2104	Хангамж, бараа материалын зардал	20,189,944,000.00	20,123,689,139.19	66,254,860.81	99.67
210401	Бичиг хэрэг	2,180,181,900.00	2,175,335,364.26	4,846,535.74	99.78
210402	Тээвэр, шатахуун	13,515,631,600.00	13,510,048,828.30	5,582,771.70	99.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,645,965,300.00	1,631,865,189.41	14,100,110.59	99.14
210404	Ном, хэвлэл	349,992,300.00	341,620,044.86	8,372,255.14	97.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	186,870,000.00	185,989,014.00	880,986.00	99.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,311,302,900.00	2,278,830,698.36	32,472,201.64	98.60
2105	Нормативт зардал	50,664,350,500.00	50,562,010,189.52	102,340,310.48	99.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,668,259,900.00	7,627,334,314.47	40,925,585.53	99.47
210502	Хоол, хүнс	20,593,260,400.00	20,553,821,398.00	39,439,002.00	99.81
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,402,830,200.00	22,380,854,477.05	21,975,722.95	99.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,255,726,300.00	21,052,556,855.08	203,169,444.92	99.04
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,366,571,100.00	8,302,967,347.82	63,603,752.18	99.24
210602	Тавилга	1,014,076,000.00	1,012,673,300.00	1,402,700.00	99.86
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,069,677,600.00	2,065,300,179.90	4,377,420.10	99.79
210604	Урсгал засвар	9,805,401,600.00	9,671,616,027.36	133,785,572.64	98.64
2107	Томилолт, зочны зардал	1,026,045,200.00	990,304,412.00	35,740,788.00	96.52
210701	Гадаад албан томилолт	26,104,300.00	26,104,140.00	160.00	100.00

210702	Дотоод албан томилолт	880,039,100.00	848,604,347.00	31,434,753.00	96.43
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	119,901,800.00	115,595,925.00	4,305,875.00	96.41
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,670,043,400.00	39,445,866,766.79	224,176,633.21	99.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,582,439,200.00	31,394,648,872.88	187,790,327.12	99.41
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	70,011,900.00	69,837,900.00	174,000.00	99.75
210803	Даатгалын үйлчилгээ	990,940,300.00	987,405,542.07	3,534,757.93	99.64
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,706,100.00	205,274,565.30	1,431,534.70	99.31
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,306,700.00	37,405,286.00	901,414.00	97.65
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,406,465,100.00	2,388,498,228.74	17,966,871.26	99.25
210807	Газрын төлбөр	407,463,200.00	405,809,394.80	1,653,805.20	99.59
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	486,300.00	229,150.00	257,150.00	47.12
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,967,224,600.00	3,956,757,827.00	10,466,773.00	99.74
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,887,436,700.00	14,841,437,091.48	1,045,999,608.52	93.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,455,247,100.00	13,416,536,433.23	1,038,710,666.77	92.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,432,189,600.00	1,424,900,658.25	7,288,941.75	99.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,641,260,400.00	49,574,234,882.79	67,025,517.21	99.86
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	818,730,400.00	816,486,164.55	2,244,235.45	99.73
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	693,867,400.00	692,292,400.00	1,575,000.00	99.77
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	124,863,000.00	124,193,764.55	669,235.45	99.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,822,530,000.00	48,757,748,718.24	64,781,281.76	99.87
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	955,431,400.00	950,255,735.00	5,175,665.00	99.46
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,538,279,000.00	3,538,178,530.24	100,469.76	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,551,739,700.00	29,516,328,618.00	35,411,082.00	99.88
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,486,196,600.00	10,486,170,382.00	26,218.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,290,883,300.00	4,266,815,453.00	24,067,847.00	99.44
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,650,200,000.00	50,125,039,207.50	525,160,792.50	98.96
220001	Барилга байгууламж	34,357,100,000.00	33,895,419,256.50	461,680,743.50	98.66
221001	Их засвар	650,000,000.00	647,664,145.00	2,335,855.00	99.64
222001	Тоног төхөөрөмж	15,643,100,000.00	15,581,955,806.00	61,144,194.00	99.61
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(20,600,744,600.00)	-	(20,600,744,600.00)	-
230001	Эргэж төлөгдөх зээл	(20,600,744,600.00)	-	(20,600,744,600.00)	-

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	605,191,728,500.00	632,069,932,377.23	(26,878,203,877.23)	104.44
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	595,477,935,500.00	591,468,273,755.25	4,009,661,744.75	99.33
310001	Улсын төсвөөс санхүүжих	595,477,935,500.00	591,468,273,755.25	4,009,661,744.75	99.33
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,448,679,600.00	9,638,197,709.00	810,481,891.00	92.24
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,448,679,600.00	9,638,197,709.00	810,481,891.00	92.24
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	19,865,858,000.00	30,963,460,912.98	(11,097,602,912.98)	155.86
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,687,712,400.00	21,711,453,034.13	(4,023,740,634.13)	122.75
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,178,145,600.00	2,186,889,742.00	(8,744,142.00)	100.40
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	7,065,118,136.85	(7,065,118,136.85)	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	(20,600,744,600.00)	-	(20,600,744,600.00)	-
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(20,600,744,600.00)	-	(20,600,744,600.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,879,762.76	(1,879,762.76)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	381,030.76	(381,030.76)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /		
Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,197,777,574.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,115,259,714.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,978,684,729.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,870,779,210.00
210101	Үндсэн цалин	1,449,420,922.25
210102	Нэмэгдэл	634,330,877.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	247,269,145.00
210104	Урамшуулал	1,902,416,264.00
210105	Гэрээт ажлын хөлс	637,342,001.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	340,791,771.14
210201	Тэтгэврийн даатгал	80,454,777.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,334.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,862,681.00
210204	Ажилгүйдлийн даатгал	551,257.00
210205	Эрүүл мэндийн даатгал	255,487,721.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,466,724.00
210301	Гэрэл, цахилгаан	9,767,464.00
210302	Түлш, халаалт	35,490,534.00
210303	Цэвэр, бохир ус	7,208,726.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,175,329,098.00
210401	Бичиг хэрэг	123,308,800.00
210402	Тээвэр, шатахуун	900,134,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,961,679.00
210404	Ном, хэвлэл	4,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,723,959.00
2105	Нормативт зардал	1,212,997,536.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,737,503.00
210502	Хоол, хүнс	1,099,624,433.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	88,635,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,089,416,614.09
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,247,012,800.19
210602	Тавилга	190,579,213.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	298,236,300.00
210604	Урсгал засвар	1,353,588,300.90
2107	Томилолт, зочны зардал	125,019,039.00
210702	Дотоод албан томилолт	125,019,039.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,221,912,873.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,219,529,472.25
210807	Газрын төлбөр	1,333,401.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,050,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,889,971,862.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,755,222,612.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	134,749,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,136,574,985.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,381,165,780.73

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	202,915,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,178,250,780.73
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	755,409,205.02
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	53,374,612.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	702,034,593.02
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,082,517,860.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,082,517,860.00
220001	Барилга байгууламж	50,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	484,760,000.00
223001	Бусад хөрөнгө	476,771,360.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	70,986,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,197,777,574.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,197,777,574.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,402,215,730.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,096,480,792.74
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,144,450,795.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,554,630,257.08

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татан буугдсан байгууллагуудын авлага, өр төлбөр, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, харьяа байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Энхжин гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, Тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүллээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1627 дугаар албан бичгээр ирүүлсэн.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоолоор тус яамны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан байна. Уг тогтоолд Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхэм зорилгыг “Үндэсний эрхэмлэн дээдлэх зүйлсийг хадгалан хамгаалах, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэн, хууль зүйн салбарын бодлого, төлөвлөлтийн үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/87 дугаар тушаалаар батлуулан санхүүгийн үйл ажиллагаандаа 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/153 дугаар “Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх тухай” тушаалаар Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус яамны Санхүү хөрөнгө, оруулалтын газарт дотоод аудит хийж, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар 8 зөвлөмж өгсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 620,815.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12,416.3 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 34,296.3 сая, эцсийн үлдэгдэл 34,730.0 сая төгрөг болж 433.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Кассад байгаа бэлэн мөнгө	75.4	101.8	26.4	0.3
Төгрөг	75.4	101.8	26.4	0.3
Банканд байгаа бэлэн мөнгө	34,211.3	34,617.8	406.4	99.7
Төрийн сангийн харилцах	11,849.0	13,866.0	2,017.0	39.9
Арилжааны банкин дахь харилцах	22,192.3	20,575.7	-1,616.6	59.2
Гадаад валют	170.1	176.1	6.0	0.5
Замд яваа мөнгөн хөрөнгө	9.6	10.4	0.8	0.0
Дүн	34,296.3	34,730.0	433.7	100.0

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдлийн 59.4 хувийг ШШГЕГ, 25.2 хувийг ЦЕГ, 5.7 хувийг ХХЕГ, 9.7 хувийг төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа бусад байгууллагууд тус тус эзэлж байна. Үүнээс 33,375.5 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 1,354.5 сая төгрөг нь төрийн өмчит үйлдвэрийн газрын үлдэгдэл байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос 2,017.0 сая төгрөгөөр өссөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гэрээний үүргийн дагуу барьцаа хөрөнгө байршуулснаас шалтгаалжээ.

Арилжааны банк дахь мөнгөн хөрөнгийн 80.6 хувь буюу 16,586.3 сая төгрөг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу иргэд, байгууллагын хоорондын шүүхийн шийдвэртэй

холбоотой төлбөр, 12.9 хувь буюу 2,654.4 сая төгрөг нь Хууль зүйн салбарын алба хаагчдын орон сууцны төлбөр байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Нийслэлийн улсын бүртгэлийн газрын үйлчилгээний 10.4 сая төгрөгийн орлого бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материал, ажил үйлчилгээнд шилжүүлсэн төлбөр цахим и-баримтын дүнгээс зөрүүтэй болон и-баримтгүй 1,266.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн /ХХЕГ 392.8 сая, ЦЕГ 820.9 сая, ШШГЕГ 50.1 сая, УБЕГ 4.0 сая, ШШҮХ 6.2 сая, бусад харьяа байгууллага 3.5 сая төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 472.6 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /ХХЕГ 14.0 сая, ЦЕГ 8.9 сая, ШШГЕГ 70.6 сая, АЕГ 363.4 сая, бусад харьяа байгууллагууд 6.1 сая төгрөг/;
- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг 46.6 сая төгрөгөөр илүү олгосон, / ХХЕГ 10.8 сая, ЦЕГ 7.9 сая, ШШГЕГ 2.1 сая, ШШҮХ 0.6 сая, УБЕГ 8.1 сая, АЕГ 1.2 сая, ТТАХНЭ 15.9 сая төгрөг/;
- Цалингийн зардлаас ахмадын санд 53.5 сая төгрөг шилжүүлсэн /ХЗДХЯ 52.0 сая, ШШГЕГ 1.5 сая/;
- Ахмадын санд мөнгө шилжүүлж, төсөв батлагдаагүй байхад урсгал зардлаас 208.9 сая төгрөг зарцуулсан /ЦЕГ/;
- Ахмадын сангаас 24.0 сая төгрөгийн зориулалт бус зардал гаргасан /АЕГ/.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 86,652.9 сая, эцсийн үлдэгдэл 90,474.6 сая төгрөг болж, 3,821.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	39.9	34.9	-5.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	54.3	122.9	68.6
Татаас, санхүүжилтийн авлага	7,067.5	11,492.3	4,424.8
Дансны авлага /ТӨҮГ/	1,961.6	1,428.3	-532.8
Татвар, НДШ-ын авлага	36.0	473.1	437.1
Бусад авлага	30,845.8	31,161.5	315.7
Байгууллагаас авах авлага	30,268.4	29,378.6	-889.2
Хувь хүнээс авах авлага	577.4	1,782.9	1,205.5
Зээлийн авлага	46,647.8	45,761.6	-886.2
Дүн	86,652.9	90,474.6	3,821.7

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 34.4 хувь буюу 31,161.5 сая төгрөгийг бусад авлага, 50.6 хувь буюу 45,761.6 сая төгрөгийг зээлийн авлага, 12.7 хувь буюу 11,492.3 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлага эзэлж байна.

Татаас санхүүжилтийн авлага өмнөх оноос 4,424.8 сая төгрөгөөр өссөн нь Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн 10,675.1 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Хувь хүнээс авах авлага 1,205.5 сая төгрөгөөр өссөн нь Хууль зүйн салбарын алба хаагчдын орон сууцны төлбөрийн авлагатай холбоотой байна.

Байгууллагаас авах авлагын 99.2 хувь буюу 29,143.9 сая төгрөг нь Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны татан буугдсан 6 банк, өрхийн амьжиргааг дээшлүүлэх төсөл, хөдөө орон нутгийн зээл төслөөс барагдуулах авлага байна. /Ард банк 7,831.9 сая, Монгол даатгал банк 2,468.0 сая, Сэргээн босголт банк 2,983.0 сая, Төв ази банк 639.9 сая төгрөг, ХОТШ банк 10,037.9 сая, Хоршоо банк 701.5 сая, Хөдөө орон нутгийн зээл 4,118.7 сая, Өрхийн амьжиргаа дээшлүүлэх төсөл 362.8 сая төгрөг/

Зээлийн авлагын 45,761.6 сая төгрөгийн үлдэгдэл нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар дампуурсан хадгаламж зээлийн хоршоодын үүсгэн байгуулагч, зээлдэгч нараас авах авлага байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 5,715.1 сая, эцсийн үлдэгдэл 6,326.5 сая төгрөг болж, 611.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн газар	74.0	73.5	-0.5
Урьдчилж гарсан зардал	4,079.6	4,113.9	34.3
Урьдчилгаа тооцоо	1,561.5	2,139.1	577.6
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,111.1	1,219.1	108.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	447.0	918.1	471.1
Цалингийн урьдчилгаа	3.3	1.9	-1.4
Томилолтын урьдчилгаа	0.1	-	-0.1
Дүн	5,715.1	6,326.5	611.4

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдлийн 58.8 хувийг ЦЕГ, 18.4 хувийг УБЕГ, 7.4 хувийг ХХЕГ, 6.8 хувийг ШШГЕГ, 8.6 хувийг төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа бусад байгууллагууд тус тус эзэлж байна. Үүнээс төсвийн байгууллагуудын үлдэгдэл 6,068.7 сая төгрөг, төрийн өмчит үйлдвэрийн газруудын урьдчилгаа төлбөр 257.9 сая төгрөг байна.

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос өссөн нь УБЕГ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тавилга эд хогшил авах 824.2 сая төгрөгийг тендерт шалгарсан байгууллагуудад шилжүүлсэн боловч Ковид-19 цар тахлын улмаас тавилга, эд хогшлыг хүлээн авах боломжгүй нөхцөл байдал үүсэж урьдчилж гарсан зардлаар тайлагнасан, гадаад паспортын бэлдэц 328.3 сая төгрөгийн зардлыг урьдчилан шилжүүлснээс тус тус шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Дараа онд хэрэгжих хөтөлбөрт 58.0 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн /ХЗДХЯ 50.0 сая, УБЕГ 8.0 сая төгрөг/;
- ШШГЕГ-аас ЦЕГ-т шилжсэн албан хаагчийн 18 сарын тэтгэмжийн урьдчилгаа төлбөр 17.5 сая төгрөгийг шилжүүлээгүй;
- ДХИС тайлант онд ноогдохгүй 11.8 сая төгрөгийн даатгалын төлбөрийг зардалд шууд бүртгэсэн.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 106,261.8 сая, эцсийн үлдэгдэл 159,658.6 сая төгрөг болж, 53,396.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	24,533.5	30,268.6	5,735.1
Дуусаагүй үйлдвэрлэл	5,148.0	32,869.1	27,721.1
Бэлэн бүтээгдэхүүн	20,121.3	22,563.2	2,441.9
Хангамжийн материал	46,140.0	54,303.6	8,163.6
Биологийн хөрөнгө	-	586.2	586.2
Мал амьтад	10,319.0	19,067.9	8,748.9
Дүн	106,261.8	159,658.6	53,396.8

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдлийн 65.5 хувь буюу 21,525.9 сая төгрөг нь ШШГЕГ-ын алба хаагчдын орон сууцны дуусаагүй барилга байна.

Мал амьтад дансны үлдэгдэл өмнөх оноос 8,748.9 сая төгрөгөөр өссөн нь малын үнийг зах зээлийн жишигт нийцүүлэн шинэчлэн тогтоосон, мөн малын нас дэвшилт, төлийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Хангамжийн бараа материал өссөн шалтгаан нь ЦЕГ-ын жолооны үнэмлэхийн бэлдэц Ковид-19 цар тахалтай холбоотойгоор бэлтгэн нийлүүлэлт төлөвлөсөн хугацаанаас хойшилсон, мөн бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан голомтод болон эрсдэлтэй бүсэд эргүүл, хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслийн худалдан авалтыг хийсэнтэй холбоотойгоор өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 546.8 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүн худалдан авсан /ШШГЕГ 297.1 сая, ХХЕГ 197.4 сая, ГИХ 16.3 сая, ХЗДХЯ 36.0 сая төгрөг/;
- Худалдан авах ажиллагааны хууль журам зөрчсөн, харьцуулалтын арга хэрэглээгүй 1,258.5 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн /ЦЕГ 51.2 сая, ШШГЕГ 1,036.6 сая, УБЕГ 138.9 сая, АЕГ 31.8 сая төгрөг/;
- Бараа материалыг зардалд шууд тусгасан /ХЗДХЯ 8.0 сая, ХХЕГ 3.8 сая, УБЕГ 0.4 сая/;
- Оны эцэст бараа материалын тооллого хийгээгүй /АЕГ 269.9 сая төгрөг/;

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 775,959.2 сая, эцсийн үлдэгдэл 938,327.6 сая төгрөг болж, 162,368.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

		/сая төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	619,998.5	649,510.1	29,511.6
Биет бус хөрөнгө	153,397.7	286,170.3	132,772.6
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	2,563.0	2,647.2	84.2
Дүн	775,959.2	938,327.6	162,368.4

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Биет хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 29,511.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 20,462.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүй болон хандив, тусламжаар 290.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэнээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө 132,772.6 сая төгрөгөөр өссөн нь газар эзэмших эрхийг үнэлж, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 81.2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн /ХХЕГ 4.4 сая, ЦЕГ 2.3 сая, ШШГЕГ 6.8 сая, ГИХГ 1.5 сая, ТТАХНЭ 66.2 сая төгрөг/;
- Элэгдлийн зардлыг 16.2 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон /ТТАХНЭ 12.9 сая, ШШГЕГ 3.3 сая төгрөг/;
- Элэгдлийн зардлаараа анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой 206.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй /ШШГЕГ 100.3 сая, УБЕГ 106.2 сая/;
- ЗГ-ын 2018 оны 304 дүгээр тогтоолоор үйл ажиллагааг нь татан буулгасан 403 дугаар хаалттай хорих үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 454.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй барилга байгууламжийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлээгүй.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 123,399.2 сая, эцсийн үлдэгдэл 123,483.4 сая төгрөг болж, 84.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	123,399.2	123,483.4	84.2	100.0
Богино хугацаат зээлийн өглөг	810.0	800.0	-10.0	0.6
Ажилчидтай холбогдсон өглөг	567.2	21.7	-545.5	0.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	20.0	2.1	-17.9	0.0
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	108.7	-	-108.7	0.0
Зээлийн хүүгийн өглөг	-	17.0	17.0	0.0
Бусад өглөг	57,581.4	48,731.8	-8,849.6	39.5
Урьдчилж олсон орлого	64,311.9	73,910.8	9,598.9	59.9
Нийт дүн	123,399.2	123,483.4	84.2	100.0

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн болон урьдчилж орсон орлогын дансны үлдэгдлийн 62.7 хувь буюу 77,504.1 сая төгрөг нь Банк хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албаны шүүхийн шийдвэрийн дагуу байгууллага, хувь хүмүүст төлөх өглөг эзэлж байна.

Бусад өглөгийн үлдэгдлийн 33.2 хувь буюу 16,165.9 сая төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн дагуу иргэд байгууллага хоорондын шүүхийн шийдвэртэй холбоотой өглөг эзэлж байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 886,402.2 сая, эцсийн үлдэгдэл 1,117,934.1 сая төгрөг болж, 231,531.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	350,424.3	482,674.8	132,250.5	43.2
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан				
Хуримтлагдсан үр дүн	322,416.1	425,328.7	102,912.6	38.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	213,561.8	209,930.6	-3,631.2	18.8
Дүн	886,402.2	1,117,934.1	231,531.9	100.0

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан дансны үлдэгдэл өссөн нь өмнөх онд үнэлэгдээгүй орхигдсон газрыг үнэлснээс шалтгаалсан байна.

Хуримтлагдсан үр дүн 102,912.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна. Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл акталсан хөрөнгийн дахин үнэлгээний буцаалт 3,631.2 сая төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 52,554.6 сая төгрөг улсын төсвийн орлогод төвлөрүүлэхээр батлагдаж, 46,485.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 88.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын бүртгэлийн ерөнхий газар	17,000.0	11,603.4	-5,396.6	68.3
Цагдаагийн ерөнхий газар	5,240.0	1,345.4	-3,894.6	25.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	10,448.7	9,638.2	-810.5	92.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	19,865.9	23,898.3	4,032.4	120.3
Нийт дүн	52,554.6	46,485.3	-6,069.3	88.5

Улсын хэмжээнд Ковид-19 цар тахал өвчний улмаас Засгийн газар болон Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа хатуу хөл хорио, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагч 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 937,966.0 сая төгрөгөөр тооцож, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны төсвийн зарлагын дээд хязгаарыг 444,856.8 сая төгрөгөөр баталсан ба төсвийн ерөнхийлөн захирагч 937,966.0 сая төгрөгийн төсвийн төсөл боловсруулж хүргүүлснийг 312,173.5 сая төгрөгөөр бууруулж 625,792.5 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарлагыг хэт өндрөөр, бодит бус, үндэслэлгүй боловсруулсан, төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцээгүй тул бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөр, 33 арга хэмжээг санхүүжүүлэхээр 625,792.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 575,142.3 сая төгрөгийг урсгал зардалд, 50,650.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар, улсын төсөвт 20,600.0 сая төгрөгийн эргэж төлөгдөх цэвэр зээлийг төвлөрүүлэхээр батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтээс 591,468.3 сая, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 23,898.3 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 9,638.2 сая төгрөгийн нийт 625,004.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж, 621,116.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 621,116.0 сая төгрөг буюу 4,675.5 сая төгрөгөөр дутуу зарцуулж, төсвийн гүйцэтгэл 99.2 хувьтай байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлээс материаллаг байдлаар дараах зардал дутуу зарцуулагдсан байна. Үүнд:

- Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 1,688.2 сая төгрөгөөр /ГИХГ 821.9 сая, ТТАХНЭ 327.1 сая, ХЗДХЯ 265.4 сая, ХЗТТ 91.7 сая, ЦЕГ 80.9 сая, .../;
- Бараа үйлчилгээний бусад зардал 1,046.0 сая төгрөгөөр /ШШГЕГ 185.4 сая, ТТАХН эмнэлэг 636.3 сая, УБЕГ 106.4 сая, .../;
- Хөрөнгийн зардал 525.1 сая төгрөгөөр /ЦЕГ 495.4 сая, ДХИС 10.5 сая, ХЗДХЯ 13.5 сая, .../ байна.

Дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодтой холбоотой авлагыг бүрдүүлж, улсын төсөвт 20,600.0 сая төгрөгийн эргэж төлөгдөх цэвэр зээлийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэл гараагүй байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсөвт 50,650.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 50,125.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын батлагдсан төсвөөс барилга байгууламжид 33,895.4 сая, их засварт 647.7 сая, тоног төхөөрөмж худалдан авалтад 15,581.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 14,452.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 1,402.2 сая, Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-аас 12,096.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 6,144.4, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,554.6 сая, нийт 34,197.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 4,870.8 сая, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 340.8 сая, байр ашиглалтын зардалд 52.5 сая, хангамжийн бараа материалын зардалд 1,175.3 сая, норматив зардалд 1,213.0 сая, эд хогшил худалдан авах зардалд 4,089.4 сая, дотоод албан томилолтод 125.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 2,221.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 7,890.0 сая, тэтгэмж урамшуулалд 10,381.2 сая, хөрөнгийн зардалд 1,082.5 сая нийт 33,442.5 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 755.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд халдварын голомтот бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад Засгийн газрын нөөц сангаас Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Хөрөнгө гаргах тухай” 179 дүгээр тогтоолоор 5,881.0 сая төгрөг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Хөрөнгө гаргах тухай” 196 дугаар тогтоолоор 3,314.4 сая төгрөгийн урамшуулал тус тус олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Хууль зүйн салбарын алба хаагчдын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд ШШГЕГ-ын хэрэгжүүлж буй орон сууцны барилгын төлбөрийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль болон Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамааралгүй бөгөөд орон сууцны барилгын эх үүсвэрийг захиалагчийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа тул аудитад хамруулаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

